

**БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.АЛТАНЦЭЦЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛГИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)					
			1	2	3	4	5			6
Зорилт 1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ-г хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт										
1.	1.1.Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сул орон тооны захиалгыг салбар зөвлөлд хүргүүлэх, төрийн албан хаагчийн тангараг өргүүлэх.	Сул орон тоо гарсан тоо, гүйцэтгэл	90%	100%	Нягтлан бодлогчийн сул орон тоонд ажилд орохоор өргөдөл ирүүлсэн Н.Мөнхжаргалын өргөдөл, анкет болон бусад холбогдох материалыг судалж аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс рүү албан бичиг төлөвлөн зөвшөөрөл хүссэн боловч мэргэжлийн шаардлага хангаагүй гэсэн хариу ирсэн. Мөн Авлигатай тэмцэх газар руу төлөвлөн явуулахад мөн мэргэжлийн шаардлага хангасан хүн томилохыг зөвлөсөн бичиг ирсэн. Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдөж, томилогдсон Багийн Засаг дарга нарын захирамж шийдвэрийг цаг тухайд нь боловсруулан батлуулж, шинээр томилогдсон багийн Засаг дарга нартай сумын Засаг даргын хамтран ажиллах гэрээг боловсруулан батлуулсан.			2025.01.02-2025.06.18	100%	
	Арга хэмжээ 1.2.Байгууллагын хүний нөөц, дотоод ажлын чиглэлээр тушаал, шийдвэрийг цаг тухайд нь боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах	Гарсан тушаал, шийдвэрийн тоо	0	60	Сумын Засаг даргын захирамжаар ажилд томилж, чөлөөлсөн 31 захирамж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 14 захирамж, хүний нөөцтэй холбоотой Тамгын газрын даргын тушаал 24, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 5 тушаал, нийт 74 захирамж, тушаал шийдвэрийг хугацаанд нь боловсруулан, хэрэгжилтэд хяналт тавьж, ажилласан. Зэрэг дэв шинээр авах болон ахиулан авах албан хаагчдын судалгааг нэгтгэн гаргаж холбогдох дээд шатны байгууллагад уламжилснаар энэ жил шинээр 5 албан хаагч зэрэг дэвийн нэмэгдэл авч эхэлсэн бол 5 албан хаагч зэрэг дэвийн нэмэгдэл ахиулан авах болзол хангаж нэмэгдэл авч ажиллаж байна.			2025.01.02-2025.06.18	100%	

Арга хэмжээ 1.3.Хүний нөөцийн системийг хөтлөх, мэдээллийг тухай бүр шинэчлэх	-Мэдээллийн бүрэн бүтэн байдал (хувь) -Мэдээлэл шинэчлэгдсэн хугацаа		70%	80%	Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлийн зөвлөмжийн дагуу байгууллагын бүтэц зохион байгуулалт баталсан тушаалын дагуу бүх албан тушаалын тодорхойлоглыг системд шивж оруулах ажлыг 3 дугаар сард багтаан хийж салбар зөвлөлөөр хянуулан ТА3-руу хянуулахаар илгээсэн. Албан хаагчдын мэдээллийг шинэчлэх ажилд эхний хагас жилийн байдлаар 80 хувьтай явагдаж байна. Албан хаагчид чөлөөлөгдөж, томилогдох, цалинд өөрчлөлт орох, зэрэг дэв нэмэгдэх зэрэг тохиолдлуудад мэдээллийг цаг тухайд нь ажлын 2 хоногт багтаан шинэчлэн оруулж хэвшсэн.	2025.01.02-2025.06.18	100%
Арга хэмжээ 1.4. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт	Мэдээллийг цахим хуудсанд болон мэдээллийн буланд байршуулсан давтамж	6	10	Албан хаагчдын мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн буланд тогтмол шинэчлэн хийж байна. Сул орон тоог хангах журмыг нийтэд буюу сумын цахим хуудсанд байршуулсан.	2025.01.02-2025.06.18	85%	
Арга хэмжээ 1.5. Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмын хэрэгжилтийг хангах	-Ажлын төлөвлөгөө албан хаагчдын хувь	0%	100%	2025 оны 02 дугаар сард Төрийн захиргааны бүх албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөөг хугацаанд нь багтаан гаргаж, томилох эрх бүхий албан тушаалтан буюу төсвийн шууд захирагчаар батлуулсан. Мөн сонгуулийн үр дүнгээр шинээр томилогдсон багийн Засаг дарга нар сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гүйцэтгэлийн үнэлгээ хийх хугацаа журмын дагуу 2025.06.25-ны дотор хийгдэх тул хурлын тэмдэглэл, баримтжуулалт, албан хаагчад танилцуулах, удирдлагад тайлагнах ажлын хугацаа болгоогүй байна.	2	2025.01.02-2025.06.18	85%
	-Гүйцэтгэлийн үнэлгээ хугацаандаа хийгдсэн хувь	0%	100%				
	-Үнэлгээний тэмдэглэл, баримтжуулалт бүрэн эсэх	0%	100%				
Арга хэмжээ 1.6. ERP системээр албан хаагчдын цаг бүртгэлийг хийж, төрийн мэдээллийг солилцуулж хэвшүүлэх	Бодитоор нэвтрэн ашиглаж буй албан хаагчдын хувь		50%	100%	2025 он гарснаар мэдээлэл технологийн ажилтантай хамтран бүх албан хаагчийг ERP цахим системд холбож бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлснээр 2025 оны эхний хагас жилийн байдлаар уг системд нийт албан хаагчид бүртгэгдсэн ба албан хаагчдын цаг бүртгэл, төрийн мэдээлэл солилцож буй байдлааг хяналт тавин ажиллаж байна.	2025.01.02-2025.06.18	100%
	Арга хэмжээ 1.7.Хүний нөөцтэй холбоотой тайлан, судалгаа, мэдээллийг ТА3	Хүргүүлсэн мэдээлэл, тайлангийн тоо	0	4+	1-р сард аймгийн ЗДТГ-т байгууллагын албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийн судалгаа, орон нутгийн нэмэгдлийн судалгааг гаргаж хүргүүлсэн. Т3-ны албан	2025.01.02-2025.06.18	100%

	болон байгууллагад хургуулэх	холбогдох мэдээлэл			хаагчдын дэлгэрэнгүй судалгаа, 2024 онд хүний нөөцийн чиглэлээр ирсэн өрөдөл гомдлын судалгаа, Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны хаагчийн ёс зүйн тухай хууль, төрийн албаны шинэтгэлийн талаар төрийн албан хаагчдад хийсэн сургалт, мэдээлэл, Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, хуулиар хүлээсэн зарим чиг үүргээ хэрэгжүүлж буй талаар дэлгэрэнгүй судалгааг гаргаж ТАЗ-ийн Булган аймаг дахь салбар зөвлөл болон ТАЗ-ийн хяналт шалгалтын ажлын хэсэгт гаргаж өгсөн.		
	Арга хэмжээ 1.8. Байгууллагын сургалт хөгжлийн төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг сургалтад хамруулах	Хамрагдсан албан хаагчдын тоо	0	60+	Байгууллагын сургалт хөгжлийн төлөвлөгөөний дагуу МАА-н үйлдвэрлэл, технологи, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн Б.Оюунбатыг ХААИС-ийн МАА, биотехнологийн сургуулиас 2025.03.21-25-ны хооронд зохион байгуулагдсан "Малын генетик нөөцийг судлан хөгжүүлэх, төлөвлөх, тайлагнах, үр чадаар олгох мэргэшүүлэх сургалт"-д байгууллагаас 280,000 төгрөгийн зардлыг гарган хамруулж, чадавхжуулсан. ХХААХҮҮҮ-аас "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ны хүрээнд Дархан-Уул аймагт 2025.03.27-ны өдөр зохион байгуулагдсан Үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчдийн салбар хуралдаан, Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн салбар хуралдаан, Жимс, жимсгэнэ, хүлэмжийн үйлдвэрлэл эрхлэгчдийн салбар хуралдаан, 2025.03.28-ны өдөр зохион байгуулагдсан "Атрын-IV аян Нэгдсэн хуралдаан"-д бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн А.Оюун, 4-р багийн тариаланч Д.Энхцэцэг нар хамрагдаж, туршлага судлаад ирсэн.	2025.01.02-2025.06.18	100.
Дундаж хувь 92.5%							
Зорилт 2. "ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт							
1.	2.1.Удирдлагын хуульд нийцсэн үүрэг, даалгаврыг шуурхай биелүүлэх, эргэн мэдээллэх	Үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлсэн хувь	100%	100%	Удирдлагаас өгсөн хуульд нийцсэн үүрэг, даалгаврыг цаг тухайд нь биелүүлэн, эргэн танилцуулдаг.	2025.01.02-2025.06.18	100%

2.	2.2. Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн хувьд дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Ёс зүйн дэд хорооны даргаар батлуулж, төлөвлөгөөний дагуу ажиллах	Гүйцэтгэлийн хувь	0%	100%	"Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлаг" хойд бүсийн зөвлөгөөнд 2025.04.06, 07-ны өдөрүүдэд Орхон аймагт зохион байгуулагдахад "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэглээ" сэдвээр оролцож ирсэн. Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн холбогдох зүйл заалтаар 2025.06.09-ний өдөр төлөвлөгөөний дагуу ёс зүйн дэд хорооны дарга албан хаагчдад сургалт орсон. Мөн байгууллагын дотоод групп булган сум-ЗДТТ	2025.01.02-2025.06.18	70%
3	2.3. Байгууллагын хурлын танхим ашиглалтад хяналт тавьж, бүртгэл хөтлөх	Хурлын танхим ашиглалтын тоо	210	210+	Байгууллагаас болон бусад байгууллагаас зохион байгуулж буй аливаа хурал, уулзалтын цагт зохицуулалт хийж, бүртгэл хөтлөн ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар хурлын танхимыг 86 удаа ашигласан байна.	2025.01.02-2025.06.18	100%
Дундаж хувь							90%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Удирдлагын шийдвэрээр нэмэлтээр гүйцэтгэсэн ажлыг чанартай сайн гүйцэтгэх	Гүйцэтгэсэн ажлын тоо	0	20+	-Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн П.Чандалдулам эрүүл мэндийн шалтгаанаар үүрэгт ажлаасаа түр чөлөөлөгдсөнтэй холбогдуулан Тамгын газрын даргын тушаалаар Хууль эрх зүйн мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 3 сар хавсран гүйцэтгэж ажилласан. Энэ хугацаанд гарсан захирамж, тушаал, шийдвэрийн эрх зүйн үндэслэлүүдийг хянах, албан хаагчдад төрийн албаны тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан. -Булган аймгийн Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Газрын харилцаа, барилга хот, байгууллагын газартай хамтран сумын иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнд тулгарч буй хүндрэл бэрхшээлд тусламж үйлчилгээ үзүүлж, гэмт хэрэг зүйн зөвлөгөө өгч, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг зөрчлийн шалтгаан, нөхцөлийг бууруулах зорилгоор удирдаж боловсруулан баталж, иргэдэд сумын албан ёсны нэгж хуудас болон 6 багийн Засаг дарга, нийгмийн ажигнууд, хэсгийн ахлагч нараар дамжуулан зар мэдээллийг хүргэж, нээлттэй хаалганы өдөрлөгийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, тайланг аймгийн Прокурорын газарт хугацаанд нь хүргүүлсэн. -Олон улсын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын "Кю сертф" ХХК-иас 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар	2025.01.02-2025.06.18	100%

					хотноо зохион байгуулсан "Олон улсын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх нь" сэдэвт онол практикийн бага хуралд чанарын багийн гишүүн Б.Алтанцэцэг, Г.Нарангэрэл нар хамрагдаж ISO 9001:2015 стандартыг хэрхэн нэвтрүүлсэн, нэвтрүүлсэн байгууллагууд тасралтгүй сайжруулалт хийж, хэрхэн үр дүнтэй ажиллаж байгаа талаар сургалт мэдээлэл авсан.		
					-Монгол улсын Сонгуулийн ерөнхий хорооноос зохион байгуулсан сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, энэ чиглэлээр сургалт судалгаа явуулах чиг үүргийн хүрээнд сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны талаарх сонгогчдын ойлголт, сонгуульд оролцохгүй байгаа шалтгааныг тодорхойлох суурь судалгаанд сумын иргэдийг хамруулсан.		
					-Сумын Засаг даргын 2025 оны ээлжийн амралтын саналыг аймгийн Засаг даргын Тамгын газарт цахим болон цаасан хэлбэрээр хугацаанд нь хүргүүлсэн.		
					-Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын "Чанарын менежментийн баг"-ийн бүрэлдэхүүн ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоо стандартыг амжилттай нэвтрүүлэн хэрэгжүүлж буй аймаг, сумдын шинэ санал санаачилга, ажил, арга хэмжээ, гаргасан өөрчлөлт, дэвшилтийн талаарх туршлагыг судлахаар 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хүрэлцэн ирэхэд Булган сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа, ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлсэнтэй холбогдуулан хийж хэрэгжүүлсэн ажлыг танилцуулан, харилцан туршлага судалсан.		
					-Аймгийн Засаг даргын Тамгын газарт "Цахим Булган" хөтөлбөрт тусгах саналыг гаргаж хүргүүлсэн.		
					-Монгол улсын Сонгуулийн ерөнхий хорооноос зохион байгуулсан сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, энэ чиглэлээр сургалт судалгаа явуулах чиг үүргийн хүрээнд сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны талаарх сонгогчдын ойлголт, сонгуульд оролцохгүй байгаа шалтгааныг тодорхойлох суурь судалгаанд сумын иргэдийг хамруулсан.		
					-Чанарын багийн гишүүний хувьд Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны асуултыг гүүл форм ашиглан боловсруулж, иргэдээс авах ажил явагдаж байна.		

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний Биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн түвшин
-----	---------------------

	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4			
1.	Хүний нөөцийн удирдлагын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдах	Хүний нөөцийн чиглэлээр хамрагдсан сургалтын тоо	1	3	Хүний нөөцийн удирдлагын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад энэ оны 3, 4 дүгээр улиралд багтаж суралцахаар төлөвлөсөн тул хугацаа болгоогүй.	01-12	(-) -Халих
2.	Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны багц сургалтаа дүүргэж гэрчилгээ авах	Судалсан багц цаг	0	13 багц цаг	Удирдлагын академийн Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд 2024 оны 02 дугаар сарын 18-ны өдөр төгсөлтийн нэгдсэн шалгалтаа амжилттай өгч, гэрчилгээгээ гардан авсан.	2024.10-2025.02	100%
3.	Монгол бичгийн унших, бичих ур чадвараа нэмэгдүүлэх	Судалсан цаг	7 хоногт 30 минут	7 хоногт 2 цаг	Монгол бичгээр бичсэн бичвэрийг тогтмол уншиж, компьютерт бичих дадлагыг долоо хоногт тогтмол 2 цаг давтаж Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлж байна.	01-12	100%
4.	Орон нутаг болон байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах	Хамрагдсан сургалтын тоо	15	30	2025 он гарснаас хойш эхний хагас жилийн байдлаар байгууллагаас болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт семинарт давхардсан тоогоор 16 удаа хамрагдсан байна.	01-12	100%
Дундаж хувь							100%
Нийт гүйцэтгэлийн дундаж хувь							95.6%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРТЫН УРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(Албан тушаал)

..... /БАЛТАНЦЭЦЭГ/
(Нэр, гарын үсэг)

..... /З.БАТБАГНАН/
(Нэр, гарын үсэг)

2025.06.18
(Огноо)

2025.06.18
(Огноо)